ERP СИСТЕМИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МОДУЛЬ

# БАРАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА БҮРТГЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Сургалт, дэмжлэгийн баг

**2024 он**

# Агуулга

**1.** **Эргэлтийн хөрөнгө** захиалах. ....................................................................3
**2.** **Үндсэн хөрөнгө** захиалах. ....................................................................6
**3.** **Дагалдах бараа бүртгэх**эд хийх алхмууд: ........................................................8
**4.** Бараа худалдан авах захиалгын жагсаалт харах. ..................................................10

# БАРАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА БҮРТГЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

## 1. Эргэлтийн хөрөнгө захиалах

1.1 **Бараа худалдан авах захиалга бүртгэх**ийн тулд бүтцийн нэгжийн захиалга хийх эрх бүхий хэрэглэгч **ERP** системийн **Худалдан авалтын модулийн Бараа** цэсийн **Бараа** дэд цэс рүү ороод тухайн захиалах барааны мэдээллийн баруун дээд буланд байрлах сагс товч дээр дарж захиалга үүсгэнэ.




*Зураг 1. Бараа худалдан авах хүсэлт үүсгэх товч*

1.2 **Бараа худалдан авах захиалгын мэдээлэл оруулах** цонх доорх байдлаар харагдах ба захиалагч дараах талбаруудыг оруулна. Үүнд:




*Зураг 2. Бараа худалдан авах хүсэлт үүсгэх цонх*

- ***Тоо хэмжээ***: Захиалга хийх тоо хэмжээ оруулна.
- ***Эргэлтийн хөрөнгийн төрөл***: Захиалгын барааны төрлийг сонгоно.
    1. *Технологийн нормчлогдсон материал*
    2. ***Тоног төхөөрөмжийн засвар, ашиглалтын материал***
    3. ***Сэлбэг, хэрэгсэл***
    4. *Барилга, байгууламжийн засварын материал*
    5. *Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйл*
    6. *Шатах, тослох материал*
    7. *Бусад материал*

* 1, 4, 5, 6, 7 дугаартай төрлийг сонгоход Эргэлтийн хөрөнгийн дэд төрөл гэсэн мөр үүсэхгүй бөгөөд **Хадгалах** товчийг дарснаар захиалгын хүсэлт үүснэ.




*Зураг 3.Төрөл сонголтоос хамааран дэд төрөл сонголт хийх*

- ***Эргэлтийн хөрөнгийн дэд төрөл***: ***Эргэлтийн хөрөнгийн төрөл*** сонголт дээр Тоног төхөөрөмжийн засвар, ашиглалтын материал, Сэлбэг, хэрэгсэл гэсэн 2 сонголтоос сонгосон үед дэд төрөл сонгогдохоор гарч ирнэ.
    1. ***Их зогсолт***
    2. ***Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар (ППР)***
    3. ***Аюулгүйн нөөц***
    4. ***Их засвар***




*Зураг 4.Төрөл сонголтоос хамааран дэд төрөл сонголт хийх*

- ***Хөрөнгийн дугаар:*** Тухайн захиалах эргэлтийн хөрөнгийг ямар үндсэн хөрөнгөд ашиглахаар захиалах гэж байгаагаас хамааран тухайн үндсэн

хөрөнгийн дугаарыг оруулж өгснөөр **Хөрөнгийн мэдээлэл** талбарт санхүү бүртгэлийн системээс үндсэн хөрөнгийн мэдээллийг татан харуулна.




*Зураг 5. Захиалагч мэдээлэл оруулах талбар*




*Зураг 6. Захиалгын нийт үнийн мэдээлэл*

Хөрөнгийн мэдээлэл дээр оруулах талбарууд:

- ***Дэлгэрэнгүй:*** Тухайн захиалах барааны талаар тайлбар оруулж өгнө.
- ***Хавсралтууд***: Захиалга хийх барааны талаар нэмэлт мэдээлэл хавсаргах боломжтой.
- ***Зураг, диаграммын хавсралтууд:*** Тухайн бараатай холбоотой зураг, диаграмм хавсаргах боломжтой.
- ***Нийт үнэ***: Тухайн барааны тоо хэмжээг нэгжийн үнээр үржүүлсэн дүн байх бөгөөд хэрэв дагалдах бараатай үед нийт үнэд дагалдах барааны нийт үнэ нэмэгдсэн байдлаар харагдана.




*Зураг 7. Захиалгын нэгжийн үнийн мэдээлэл*

Барааны мэдээлэл хэсэгт:

- ***Нэгжийн үнэ***: Эргэлтийн хөрөнгийн нэгжийн үнийн мэдээлэлд Маркетингийн хэлтсээс судалсан зах зээлийн үнэ татагдаж харагдана.
- Үндсэн хөрөнгийн нэгжийн үнийн мэдээлэлд Захиалагч, барааны хүсэлт үүсгэхдээ оруулсан төсвийн үнэ харагдана.

**2. Үндсэн хөрөнгө** захиалах.

- Бүтцийн нэгжийн захиалга хийх эрх бүхий хэрэглэгч **ERP** системийн **Худалдан авалтын модулийн** **Бараа** цэсийн **Бараа** дэд цэс рүү орood тухайн захиалах барааны мэдээллийн баруун дээд буланд байрлах сагс товч дээр дарж захиалга үүсгэнэ.




*Зураг 8. Бараа худалдан авах хүсэлт үүсгэх товч*

- **Бараа худалдан авах захиалгын мэдээлэл оруулах** цонх доорх байдлаар харагдах ба захиалагч дараах талбаруудыг оруулна. Үүнд:




*Зураг 9. Бараа худалдан авах хүсэлт үүсгэх цонх*

➢ **Үндсэн хөрөнгийн төрөл** сонголт дээр **Шинэ** болон **Шинэчлэх** гэсэн сонголт орж ирнэ.




*Зураг 10. Үндсэн хөрөнгийн төрөл*

➢ **Шинэ** төрлийг сонгосон бол Үндсэн хөрөнгийн чиглэл сонгоод Хадгалах товчийг дарснаар таны худалдан авалтын захиалга үүснэ.




*Зураг 11. Үндсэн хөрөнгийн чиглэл сонгох*

➢ **Шинэчлэх** төрөл сонгосон бол Үндсэн хөрөнгийн чиглэлийг мөн сонгоод тухайн шинэчлэх шаардлагатай барааны **Хөрөнгийн дугаар**ыг оруулж **Enter** товч дарснаар **Хөрөнгийн мэдээлэл** хэсэгт тухайн хөрөнгийн мэдээллийг санхүү бүртгэлийн системээс татан харуулна.




*Зураг 12. Үндсэн хөрөнгийн төрөл, шинэчлэх сонголт*

3. **Дагалдах бараа бүртгэх**эд хийх алхмууд:
   - ➢ **Захиалгууд** цэсийн **Бараа** дэд цэсийг сонгон ороход таны захиалга хийж үүсгэсэн бараанууд харагдана.




*Зураг 13. Захиалга үүсгэсэн бараа харах*

   - ➢ Захиалгын жагсаалтаас дагалдах бараа, үйлчилгээ нэмж оруулах шаардлагатай захиалгыг сонгож ороод **Дагалдах бараа таб** цонхны **Нэмэх** товч дээр дарна. Гарч ирсэн нэмэлт цонхноос дагалдах бараагаар оруулах барааг хайлт хийн **Сонгох** товчийг дарж оруулаад тус бүрийн тоо хэмжээг оруулна. Ингэснээр тухайн захиалгын үндсэн мэдээлэлд **Нийт үнэ /Дагалдах/** талбарт дагалдах бараагаар оруулсан бараануудын нийт үнийн дүнг харуулна. **Tags filter** – товчоор шошготой бараанаас сонголт хийж иж бүрдэл болгон оруулах боломжтой.




*Зураг 14. Дагалдах бараа нэмэх*




*Зураг 15. Дагалдах бараа сонгох*




*Зураг 16. Дагалдах барааны жагсаалт, тоо хэмжээ оруулах*




*Зураг 17. Өөрчлөлтөө хадгалах товч*

- Бараа худалдан авах захиалгын хүсэлтийг үүсгэхэд **Ноорог** төлөвтэй байх бөгөөд **Эхлэх** товчийг дарснаар тухайн захиалга **Хяналтын шат**анд илгээгдэнэ.




*Зураг 18. Бараа худалдан авах хүсэлтийн явцын төлөв, Захиалагч эхлэх товчоор хяналтын шатанд илгээнэ.*




*Зураг 19. Эхлэх товчийг дарж хяналтын шатанд илгээгдсэн төлөв*

**4.** Бараа худалдан авах захиалгын жагсаалт харах.
Бараа худалдан авах захиалгын жагсаалтыг **Захиалгууд** цэсийн **Бараа** дэд цэсээр орж харна.




*Зураг 20. Бараа худалдан авах хүсэлтийн жагсаалт харах*

➢ Бараа худалдан авалтын захиалгын хүсэлтийн жагсаалтад нэмэлт шаардлагатай утгуудыг харахдаа жагсаалтын нэрийн ард талд байрлах зэрэгцсэн сум дээр дарж өөрийн харахыг хүссэн мэдээллээ сонгон нэмж оруулна.




*Зураг 21. Бараа худалдан авах хүсэлтийн жагсаалтад нэмэлтээр харах талбарууд*

➢ Захиалагч бараа худалдан авах хүсэлтээ хяналтын шат руу илгээсэн бол **Баталгаажуулалт**ын цонх харагдана.




*Зураг 22. Бараа худалдан авах хүсэлтийн баталгаажуулалт хийх эрх бүхий хэрэглэгчдийн жагсаалт*

- **Хайлтын цонхыг** ашиглан өөрт шаардлагатай талбараар барааны мэдээллийг шүүж харах боломжтой. Мөн **Өөриймшүүлсэн шүүлтүүр** нэмэх болон **Өөриймшүүлсэн бүлэг нэмэх** хэсгээр өөрт шаардлагатай хайлтын утгуудаар хайлтыг хийж **Хайлтыг хадгалах** хэсгийн нэр бичих талбарт нэр өгч хадгалан байнгын шүүлтүүр болгон ашиглах боломжтой.




*Зураг 23. Хайлтын цонх ашиглах*

# БАРАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА ХИЙХ ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

1. Бараа худалдан авалтын захиалгын хүсэлт баталгаажуулалт хийх эрх бүхий хэрэглэгчид нь ERP системийн Худалдан авалтын модулийн **Захиалгууд** цэсийн **Бараа** дэд цэсээр орсноор худалдан авалтын хүсэлтүүд жагсаалт байдлаар харагдана.




*Зураг 24. Худалдан авалтын хүсэлтүүд*

2. Хяналт баталгаажуулалт хийх шаардлагатай хүсэлтүүд нь хэрэглэгчийн баталгаажуулалт хэсэгт **EMC Purchase request**- мэдэгдлээр ирсэн байна.




*Зураг 25. Хяналт баталгаажуулалт хийх мэдэгдлийн хэсэг*

3. Хяналт баталгаажуулалт хийх захиалгын хүсэлтийг хайх цонх ашиглан харах бол хайх цонхноос **Миний баталгаажуулах** сонголтыг сонгож харж болно.




*Зураг 26. Хайх цонх ашиглан хяналт баталгаажуулалт хийх хүсэлтийн жагсаалт харах*

4. Хяналтын шатанд ирсэн захиалгын хүсэлт дээр дарж орсноор тухайн хяналт баталгаажуулалт хийх хүсэлтийг дэлгэрэнгүй байдлаар харах ба тухайн захиалах барааны нэр дээр дарснаар барааны дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

Захиалгын хүсэлтийн мэдээллүүдтэй танилцаж хангалттай гэж үзвэл **Батлах** товчоор дараагийн шатанд илгээнэ.




*Зураг 27. Хяналт баталгаажуулалтын шилжих төлөв*

5. Бараа худалдан авалтын хүсэлт нь хяналтын шатанд хаана, ямар бүтцийн нэгж дээр явж байгаа нь төлөвөөр харагдана. Доорх зураг дээр тухайн захиалгын хүсэлт нь шат шатны баталгаажуулалт хийгдсэн, зөвшөөрсөн төлөвт шилжсэн харагдаж байна.




*Зураг 28. Хяналт баталгаажуулалт шилжих төлөв*



Барааны мэдээлэл | Дагалдах бараа | Баталгаажуулалт

| Дараалал | Нэр | Хүсэлт гаргасан | Төлөв | Батлах | Баталсан | Баталсан огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БН удирдлага | Т Т.Баярмагнай | Батлсан | З З.Бямба-Од | З З.Бямба-Од | 2024-06-17 16:36:03 | |
| 2 | Үйлдвэрлэл, техникийн хэлтэс | Т Т.Баярмагнай | Батлсан | Б Б.Батжаргал | Б Б.Батжаргал | 2024-06-17 16:39:22 | |
| 3 | Д.Эрдэнэбаатар /Үйлдвэрлэл, техникийн бодлогын газар/ | Т Т.Баярмагнай | Батлсан | Д Д.Эрдэнэбаатар | Д Д.Эрдэнэбаатар | 2024-06-17 16:49:52 | |

*Зураг 29. Хяналт баталгаажуулалт хийгдсэн байдал*

*Сургалт, дэмжлэгийн баг*